ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: ДАА-2024/16/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Ахлах аудитор Х.Сувдмаа**

Утас: 70373089 Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2024 он

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 57

танай ______________-ны №______________ -т

ДАРХАН -УУЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА М.ХУВЬЗАЯА ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус хэлтсийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 19,920.0 мянган төгрөгийн архивын нягтаршуулсан шүүгээг ТӨБЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А-1/1279 тоот тогтоолоор УБЕГ-т балансаас балансад шилжүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон, мөн Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 272 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг тооцож олгосон байна.

### Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 33 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлснийг УБЕГ-ын дарга 85.00 хувиар үнэлж, "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

009020038

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ... 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 10.

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... .12

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан** ... 14

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ... 15

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ... 15

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин** ... 15

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** ... 15

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд** ... 16

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ... 16

**3.5.1 Төсвийн төлөвлөлт** ... 16

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл** ... 16

**3.5.3 Нэмэлт төсөв** ... 17

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ... 17

**4.1 Ерөнхий зүйл** ... 17

**4.2 Материаллаг байдал** ... 18

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ... 18

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ... 18

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ... 18

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ... 18

**4.5.1 Завсрын аудитын талаар** ... 18

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ... 18

**5.3 Зөвлөмж** ... 19

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ... 20


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТБОНӨХБАУХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ҮОМШӨ | Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| ГХБХБГ | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 57,191,774.11 | 27,544,986.23 |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 10,545,667.11 | **11,644,864.23** |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 10,545,667.11 | **6,279,641.23** |
| **3121** | Төгрөг | 10,545,667.11 | **6,279,641.23** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 4,013,133.91 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 10,545,667.11 | 2,266,507.32 |
| 31400 | Замд яваа мөнгөн хөрөнгө | | 5,365,223.00 |
| 33 | АВЛАГА | 19,932,600.00 | - |
| 33101 | Ажиллагсадтай холбогдсон зардал | 12,600.00 | |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 19,920,000.00 | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | **26,713,507.00** | **15,900,122.00** |
| **351** | **Түүхий эд материал** | 4,305,752.00 | 7,410,042.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,305,752.00 | 7,410,042.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 2,162,945.00 | 3,613,170.00 |
| 354 | **Хангамжийн материал** | **20,244,810.00** | **4,876,910.00** |
| 35420 | Аж ахуйн материал | 1,937,810.00 | 1,937,810.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 289,000.00 | 289,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,018,000.00 | 2,650,100.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **168,366,857.32** | **203,992,955.28** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **168,366,857.32** | **203,992,955.28** |
| 392 | **Биет хөрөнгө** | **168,366,857.32** | **203,992,955.28** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 98,454,296.80 | 98,454,296.80 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (9,376,599.84) | (11,720,749.80) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 58,000,000.00 | 58,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (58,000,000.00) | (58,000,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 199,944,123.28 | 168,646,112.39 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (120,986,062.53) | (60,897,204.16) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27,980,500.00 | 41,318,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (27,649,400.39) | (31,807,499.95) |
| 39301 | Программ хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,724,520.07 | |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (9,724,520.07) | |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 225,558,631.43 | 231,537,941.51 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | **10,545,667.11** | **7,631,730.32** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 10,545,667.11 | 7,631,730.32 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | 10,545,667.11 | 7,631,730.32 |
| 41410 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 10,545,667.11 | 7,631,730.32 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 215,012,964.32 | 223,906,211.19 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **215,012,964.32** | **223,906,211.19** |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **144,985,909.21** | **153,879,156.08** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 129,227,126.53 | 144,985,909.21 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 15,758,782.68 | 8,893,246.87 |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 70,027,055.11 | 70,027,055.11 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 225,558,631.43 | 231,537,941.51 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **484,231,506.53** | **880,764,076.02** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **45,286,706.53** | **97,345,476.02** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 45,286,706.53 | 97,345,476.02 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 45,286,706.53 | 93,332,342.11 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө | 31,400,981.53 | 66,554,377.11 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал | 13,885,725.00 | 26,777,965.00 |
| 140020 | Бусад орлого | | 4,013,133.91 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **438,944,800.00** | **783,418,600.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 438,944,800.00 | 716,620,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 438,944,800.00 | 716,620,700.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **66,797,900.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 66,797,900.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **461,972,723.85** | **852,614,829.15** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **461,972,723.85** | **852,614,829.15** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 460,593,975.85 | 850,784,825.99 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 319,447,700.00 | 612,598,422.00 |
| 210101 | Үндсэн цалин | 257,925,032.00 | 390,643,615.76 |
| 210102 | Нэмэгдэл | 55,809,268.00 | 162,740,359.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,713,400.00 | 41,771,662.64 |
| 210104 | Урамшуулал | | 17,442,784.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,963,800.00** | **102,319,778.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,295,400.00 | 78,927,678.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,160,200.00 | 8,773,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,090,600.00 | 3,898,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 878,550.18 | 974,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,539,049.82 | 9,746,100.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **34,020,000.00** | **34,020,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 34,020,000.00 | 34,020,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **16,873,450.00** | **16,382,784.84** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,474,172.00 | 11,654,133.83 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,380,000.00 | 1,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,818,452.00 | 1,747,951.01 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,200,826.00 | 1,480,700.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,517,650.00** | **6,628,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 967,900.00 | 3,111,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 389,500.00 | 3,517,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 160,250.00 | |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **23,661,365.60** | **30,539,762.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 842,790.00 | 4,751,312.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 65,340.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,212.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 4,000,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 22,675,023.60 | 21,788,450.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **22,110,010.25** | **48,296,079.15** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 15,733,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 386,700.00 | 970,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21,723,310.25 | 31,592,279.15 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,378,748.00** | **1,830,003.16** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **600,000.00** | **1,066,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 1,066,000.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 778,748.00 | 764,003.16 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 778,748.00 | 764,003.16 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 22,258,782.68 | 28,149,246.87 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 6,500,000.00 | 19,256,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 6,500,000.00 | 19,256,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (6,500,000.00) | (19,256,000.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 15,758,782.68 | 8,893,246.87 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **832,889,385.25** | **1,243,454,604.42** |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **393,944,585.25** | **464,049,138.33** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **393,944,585.25** | **460,036,004.42** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 393,944,585.25 | 460,036,004.42 |
| 120003 | Тэмдэгтийн хураамжийн орлого | 393,944,585.25 | 456,022,870.51 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | 4,013,133.91 |
| 140020 | Бусад орлого | | 4,013,133.91 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **438,944,800.00** | **783,418,600.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 438,944,800.00 | 716,620,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 438,944,800.00 | 716,620,700.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 66,797,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөренге | | 66,797,900.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **823,146,011.29** | **1,242,355,407.29** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **823,146,011.29** | **1,242,355,407.29** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **436,866,052.00** | **781,588,596.83** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **319,460,300.00** | **612,585,822.00** |
| 210101 | Үндсэн цалин | 257,937,632.00 | 390,988,798.35 |
| 210102 | Нэмэгдэл | 55,809,268.00 | 162,382,577.01 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,713,400.00 | 41,771,662.64 |
| 210104 | Урамшуулал | | 17,442,784.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,963,800.00** | **102,319,778.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,295,400.00 | 78,927,678.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,917,100.00 | 8,773,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,333,700.00 | 3,898,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 583,400.00 | 974,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,834,200.00 | 9,746,100.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **34,020,000.00** | **34,020,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 34,020,000.00 | 34,020,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **15,837,500.00** | **16,234,996.83** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,625,722.00 | 11691865.83 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,380,000.00 | 1500000 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,818,452.00 | 1615731 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,013,326.00 | 1427400 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **22,250,400.00** | **6,707,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,487,400.00 | 3109000 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 440,400.00 | 3521000 |
| 210604 | Урсгал засвар | 322,600.00 | 77000 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,746,352.00** | **8,721,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,602,800.00 | 4,721,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 65,340.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,212.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 4,000,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 587,700.00 | 1,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 587,700.00 | 1,000,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 386,279,959.29 | 460,766,810.46 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 600,000.00 | 1,066,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 1,066,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 349,816,581.51 | 409,554,394.50 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 349,816,581.51 | 408,790,391.34 |
| 213306 | Улсын төсөвт төвлөрүүлэх | | 764,003.16 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 35,863,377.78 | 50,146,415.96 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,863,377.78 | 50,146,415.96 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 9,743,373.96 | 1,099,197.13 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 700,000.00 | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 700,000.00 | |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 700,000.00 | |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (700,000.00) | |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 9,043,373.96 | 1,099,197.13 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,502,293.15 | 10,545,667.11 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 10,545,667.11 | 11,644,864.24 |

## 2.4 Өмчийн өөрчлөлтийн тайлан

/ Төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | | **70,027,055.11** | **129,227,126.53** | | **199,254,181.64** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | **70,027,055.11** | **129,227,126.53** | | **199,254,181.64** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 15,758,782.68 | | 15,758,782.68 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | **70,027,055.11** | **144,985,909.21** | | **215,012,964.32** |
| D01 | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | | **70,027,055.11** | **144,985,909.21** | | **215,012,964.32** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | **70,027,055.11** | **144,985,909.21** | | **215,012,964.32** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 8,893,246.87 | | 8,893,246.87 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | **70,027,055.11** | 153,879,156.08 | | **223,906,211.19** |

XTO5430 ● 9622899

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | (10,545,667.11) | (10,545,667.11) | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **716,620,700.00** | **715,856,696.84** | **(764,003.16)** | **99.9** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **716,620,700.00** | **715,856,696.84** | **(764,003.16)** | **99.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **715,120,700.00** | **714,790,696.84** | **(330,003.16)** | **100.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **556,624,700.00** | **556,294,700.00** | **(330,000.00)** | **99.9** |
| 210101 | Үндсэн цалин | 415,032,000.00 | 378,563,551.37 | **(36,468,448.63)** | 91.2 |
| 210102 | Нэмэгдэл | 105,280,700.00 | 118,516,701.99 | **13,236,001.99** | 112.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,312,000.00 | 41,771,662.64 | **26,459,662.64** | 272.8 |
| 210104 | Урамшуулал | 21,000,000.00 | 17,442,784.00 | **(3,557,216.00)** | 83.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **91,813,000.00** | **91,813,000.00** | - | **100.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,420,900.00 | 68,420,900.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,773,000.00 | 8,773,000.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,898,400.00 | 3,898,400.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 974,600.00 | 974,600.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,746,100.00 | 9,746,100.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **34,020,000.00** | **34,020,000.00** | - | **100.0** |
| 210304 | Байрны түрээс | 34,020,000.00 | 34,020,000.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **16,235,000.00** | **16,234,996.84** | **(3.16)** | **100.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 11,489,000.00 | 11,691,865.83 | **202,865.83** | 101.8 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,750,000.00 | 1,615,731.01 | **(134,268.99)** | 92.3 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,496,000.00 | 1,427,400.00 | **(68,600.00)** | 95.4 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,707,000.00** | **6,707,000.00** | - | **100.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,109,000.00 | 3,109,000.00 | - | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,521,000.00 | 3,521,000.00 | - | 100.0 |
| | Урсгал засвар | 77,000.00 | 77,000.00 | - | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,721,000.00** | **8,721,000.00** | - | **100.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,721,000.00 | 4,721,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** | - | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,500,000.00** | **1,066,000.00** | **(434,000.00)** | **71.1** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,500,000.00** | **1,066,000.00** | **(434,000.00)** | **71.1** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,066,000.00 | **(434,000.00)** | 71.1 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **716,620,700.00** | **715,856,696.84** | **(764,003.16)** | **99.9** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **716,620,700.00** | **715,856,696.84** | **(764,003.16)** | **99.9** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 716,620,700.00 | 715,856,696.84 | **(764,003.16)** | 99.9 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **(10,545,667.11)** | **(10,545,667.11)** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **(11,644,864.23)** | **(11,644,864.23)** | **-** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **29.00** | **29.00** | - | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26.00 | 26.00 | - | 100.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 02.00 | 02.00 | **-** | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **29.00** | **29.00** | - | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 22.00 | 22.00 | **-** | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 05.00 | 05.00 | - | 100.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 02.00 | 02.00 | **-** | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тайлан он |
|---|---|---|
| **11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **66,797,900.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **66,797,900.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **66,797,900.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **56,291,122.00** |
| 210101 | Үндсэн цалин | 12,425,246.98 |
| 210102 | Нэмэгдэл | 43,865,875.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **10,506,778.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,506,778.00 |
| 13 | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **66,797,900.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **66,797,900.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 66,797,900.00 |
| **12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант онд 1 хөтөлбөр, 2 арга хэмжээг төлөвлөн иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэж, орон нутагт төрийн бүртгэлийн тогтолцоог тогтмол сайжруулж, аймгийн нийгмийн хөгжилд бодит дэмжлэг үзүүлэх зорилготой байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд "Нэгдмэл тогтолцоо, арга зүйтэй байх, төвлөрсөн удирдлагатай байх, хараат бус байх, үнэн зөв, бодитой, заавал биелүүлэх шинжтэй байх, нотлох баримтад үндэслэж, хуульд заасан журмын дагуу хөтлөх, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэж, хуулиар тогтоосон нууцыг чанд хадгалах, хуульд зааснаас бусад тохиолдолд улсын бүртгэлийн талаарх мэдээлэл ил тод, нээлттэй, нийтэд хүртээмжтэй байлгах" гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,979.3 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 10,545.7 | 11,644.8 | 1,099.1 |
| Авлага | 19,932.6 | - | (19,932.6) |
| Бараа материал | 26,713.5 | 15,900.1 | (10,813.4) |
| Үндсэн хөрөнгө | 168,366.8 | 203,992.9 | 35,626.1 |
| **Нийт хөрөнгө** | **225,558.6** | **231,537.8** | **5,979.3** |
| Өр төлбөр | 10,545.6 | 7,631.7 | (2,913.9) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 215,013.0 | 223,906.2 | 8,893.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **225,558.6** | **231,537.9** | **5,979.3** |

Үйлчилгээний орлогыг төвлөрүүлдэг дансны үлдэгдэл 11,644.8 мянган төгрөг байна.

Тайлант онд бараа материал 10,813.4 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагын хэрэгцээнд 25,229.7 мянган төгрөгийн материал бэлтгэсэн, УБЕГ-аас 26,777.9 мянган төгрөгийн үнэт цаас шилжүүлэн авч, 62,821.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Харин үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 19,920.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн, УБЕГ-аас 40,597.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 16,320.0 мянган төгрөгийн тавилгыг шилжүүлэн авсан, ТӨБЗГ-ын 2023 оны 645 дугаар тогтоолоор анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг 19,625.7 мянган төгрөгөөр дахин үнэлсэн зэргээс шалтгаалан 96,463.2 мянган төгрөгөөр өссөн байна. Харин ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 681 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 64,976.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, УБЕГ-т 19,920.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, тайлант онд 31,592.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцооны өөрчлөлт нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 463,652.4 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг 100 хувь улсын төсвөөр бүрдүүлэхээр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 252,968.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 716,620.7 мянган төгрөгөөр баталжээ.

Энэ нь цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингийн зардлыг 164,878.3 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 79,659.0 мянга, мэдээлэл технологид 4,000.0 мянга, хичээл үйлдвэрлэлд 1,000.0 мянга, хөдөлмөр хамгааллын зардалд 3,521.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэх 716,620.7 мянган төгрөгийг 100 хувь улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.
Гүйцэтгэлээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 715,856.7 мянган төгрөгийг зарцуулж, 764.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 715,856.7 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын зардлыг 330.0 мянга, тэтгэмж урамшуулал 434.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70406-Улсын бүртгэл мэдээлэл | 716,620.7 | 715,856.7 | (764.0) | 99.8 |
| 1.1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 715,120.7 | 714,790.7 | (330.0) | 99.8 |
| 1.2 | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж | 1,500.0 | 1,066.0 | (434.0) | 72.3 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгаас Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 272 дугаар тогтоолоор 66,797.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд 56,291.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 10,506.9 мянган төгрөгийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Сувдмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/106 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.
Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 716,620.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,166.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус хэлтэс нь тайлант онд шуудан холбоо, интернэтийн төлбөрийг 134.3 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллыг 434.0 мянга, хангамж бараа материалын зардлын 68.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 775,589.8 мянган төгрөгийн 19 орлогын гүйлгээг хугацаанд нь мэдээлжээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/821 тоот албан бичгээр ирүүлснийг шалгахад 100 хувь хэрэгжсэн байлаа.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | | 1 | | 100% |
| **Нийт дүн** | 1 | | 1 | | **100%** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тус газар нь өнгөрсөн онд архивын нягтаршуулсан шүүгээ худалдан авахад 19,920.0 мянган төгрөгийг урьдчилан төлж авлагаар бүртгэснийг тайлант онд үндсэн хөрөнгөд тайлагнасан боловч хөрөнгийг хүлээн аваагүй байна. Мөн дээрх хөрөнгийг ТӨБЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А-1/1279 тоот тогтоолын дагуу УБЕГ-т балансаас балансад шилжүүлсэн байна.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар өмчийн өөрчлөлтийн тайланд 144,985.9 мянган төгрөг дутуу тайлагнасан алдаа[1] гарсныг залруулав . Үүнд:

Өмчийн өөрчлөлтийн тайланд санхүүгийн байдлын тайлангийн өмнөх үеийн үр дүн 144,985.9 мянган төгрөгийг дутуу илэрхийлсэн нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн тодруулга", "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн өмчийн өөрчлөлтийг тайланг дээрх дүнгээр нэмэгдүүлэн залруулав.

Мөн санхүүгийн тайлан, төлөвлөлт, төсвийн зарцуулалт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 6,513.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 3 зөвлөмж өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Төсвийн зардалтай холбоотой асуудал*

*1.1 Илрүүлэлт:*

Тайлант онд албан хаагчдад гамшгаас хамгаалах сургалтад зориулан ажлын хувцас авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Батлагдсан төсвөөс дүрэмт хувцас болон бусад хувцас хэрэглэл авахгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. *Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал*

*2.1 Илрүүлэлт:*

Тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газрыг ГХБХБГ-аас авсан лавлагаатай тулган шалгахад 1,400.0 мкв талбайтай 1 эзэмшлийн газрыг бүртгэлд тусгаагүй байгаа нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т заасантай нийцэхгүй байна

*Өгсөн зөвлөмж:*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайланд тусгаагүй газрыг үнэлж, биет бус хөрөнгөөр бүртгэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх

3. *Төсвийн төлөвлөлтэй холбоотой асуудал*

*3.1 Илрүүлэлт:*

Төсөвт тусгагдаагүй 4,013.1 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3-т заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3-т заасныг хэрэгжүүлж, санд төвлөрүүлэх хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэлэс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмчийн өөрчлөлтийн тайланд 144,985.9 мянган төгрөг дутуу тайлагнасан | 1 | 144,985.9 | | | 1 | 144,985.9 | 1 | 144,985.9 | | | | |
| Дүн | 1 | 144,985.9 | - | - | 1 | 144,985.9 | 1 | 144,985.9 | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үнэлэс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

[2] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Албан хаагчдад гамшгаас хамгаалах сургалтад зориулан хувцас авсан | 1 | 2,500.0 | - | - | - | - | 1 | 2,500.0 | - | - | - | - |
| 1,400.0 мкв талбайтай 1 эзэмшлийн газрыг бүртгэлд тусгаагүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Төсөвт тусгагдаагүй 4,013.1 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн | 1 | 4,013.1 | | | | | 1 | 4,013.1 | | | | |
| Дүн | 3 | 6,513.1 | - | - | - | - | 3 | 6,513.1 | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | - | - | - | - | - | - | - | - |